

АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫН 2011 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

*Илтгэгч: Захиргаа, удирдлагын хэлтсийн
дарга Б.Түвшинжаргал.*

АГУУЛГА

1. 2011 онд дэвшүүлсэн зорилтуудын тухай
2. 2011 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан
3. Цаашдын зорилтууд



1.2011 онд дэвшүүлсэн зорилтууд

➤ **Геологийн судалгааг өргөжүүлэх:**

- Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж буй геологи, судалгааны ажлыг эрчимжүүлэх, чанаржуулах;
- Хувийн хөрөнгөөр хийгдэж буй геологи, судалгааны ажлын үр өгөөжийг дээшлүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулах;
- Монгол орны геологи, ашигт малтмалын судалгааны нэгдсэн сан бүрдүүлэх.

➤ **Уул уурхайн үйлдвэрлэлийг хөгжүүлэх:**

- Ашиглалтын үеийн нөөцийн ашиглалт бүртгэл хяналтыг дээшлүүлэх;
- Уулын үйлдвэрт ашиглагдаж байгаа техник, технологийн түвшин тогтоох, сайжруулах;
- Байгаль орчны нөхөн сэргээлтийг хэвшүүлэх, чанарыг дээшлүүлэх;
- Уулын ажлын төлөвлөгөө, тайлангийн цахим системийг нэвтрүүлэх.

➤ **Үргэлжлэл:**

- Уул уурхайн төслүүдэд хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах боломжийг судлан аж ахуйн нэгжүүдийг мэдээллээр хангаж, хамтран ажиллах;
- Боловсруулах үйлдвэрүүд байгуулахыг бодлогоор дэмжих.

➤ **Нүүрсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх:**

- “Нүүрс” хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулан, батлуулах;
- Нүүрсний уурхайнууд болон ордуудын нөөц баялгийн талаар мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж ажиллах, хяналтыг сайжруулах;
- Түүхий нүүрсний экспортыг аажмаар бууруулж, угааж баяжуулсан нүүрс, металлургийн кокс бусад нүүрсний гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр судалгаа шинжилгээ хийх, бодлогоор дэмжих;
- Түүхий нүүрсний хэрэглээг багасгах, хотын утааг бууруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.

➤ **Кадастрын бүртгэлийг боловсронгуй болгох:**

- ГУУ-н кадастрыг хуулийн дагуу, чанд хөтлөх, хуулийн хэрэгжилтийг чангатгах, хууль сахиулах;
- Сонирхогч талууд, олон нийтийг мэдээллээр ил тод, нээлттэй хангах, шударгаар үйлчлэх;
- Кадастрын шинэ системийг нэвтрүүлэх;
- Үйлчлүүлэгчдийн санал, гомдлыг барагдуулж, үйлчилгээний чанарт үлэмж ахиц гаргах, тэдний сэтгэл ханамжийг дээшлүүлэх.

➤ **Захиргааны удирдлагын манлайллыг хангах:**

- Шаардлагатай дүрэм, журмыг шинэчлэх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, авлигатай тэмцэх ажлыг зохион байгуулах;
- Агентлагийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, нийгэмд үнэн бодитой мэдээллийг түгээх;
- Гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Улсын төсвийн орлогын даалгаврыг бүрэн ханган биелүүлэх;
- Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмолжуулснаар байгууллагын үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх.




2. 2011 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан.



Геологи судалгааны чиглэлээр.

Геологийн судалгааны ажилд улсын төсвөөс зарцуулж байгаа хөрөнгө (сая төгрөгөөр)



2011 онд Улсын төсвийн хөрөнгөөр 1:50000-ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил, УГЗ-200, агаарын геофизик, гидрогеологи-геоэкологи болон сэдэвчилсэн судалгааны чиглэлээр үргэлжлэн хэрэгжих 19, шинээр эхлэх 14 буюу нийт 33 төлийн ажлыг 4,0 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр төлөвлөгдсөн.

Энэ 2011 онд:

- ✓ УГЗ-200 ажил - 341704км² талбайд;
- ✓ 50 000-ны ГЗБЭА - 20152км² талбайд;
- ✓ Өмнийн говийн районд гидрогеологи-экологийн судалгаа - 64749км² талбайд;
- ✓ Сайншандын районд агаарын геофизикийн судалгаа - 13120км² талбайд тус тус гүйцэтгэсэн байна.



Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд өнөөдрийн байдлаар нийт нутаг дэвсгэрийн, хүрэх боломжгүй мөстлөг, тайгын таг зэргийг хасан тооцвол 99.4 хувь нь 1:200 000-ны масштабтай геологийн зураглал, 27.4 хувь нь 1:50 000-ны масштабтай зураглалын ажлаар бүрхэгдээд байна.

Нийт нутгийн 70 гаруй хувь нь төрөл бүрийн масштабтай агаарын геофизикийн судалгааны ажилд хамрагдсанаас гадна хүдийн хүч, цахилгаан ба чичирхийллийн зэрэг гадаргуугийн геофизикийн ажлуудыг хүдрийн дүүрэг, зангилаа, орд газруудын хэмжээнд явуулж байна.

ГЕОЛОГИ, СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

Геологийн судалгааны хамтарсан төслүүд


Гадаад хамтын ажиллагааны төслүүд, найрлагын стандарт, мезокайнозой зэрэг бусад сэдэвчилсэн төслүүд амжилттай хэрэгжсэн. Монгол, ОХУ, Казакстан, БНХАУ, БНСУ-уудтай хамтран Төв Ази болон зэргэлдээх нутгуудын 1:2500 000-ны масштабтай Геологийн зургуудын Атлас төслийн 2-р шат, Монгол Улс болон БНХАУ-ын хилийн дагуух 200 км өргөнтэй зурвас бүсийн геологийн болон геохимийн зургийг 1:1000000-ны масштабтай зохиох төслүүд үргэлжилж байна.



Энэ төслийн хүрээнд Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдсэн региональ геофизикийн судалгааны материалд боловсруулалт хийж ОХУ, БНХАУ зэрэг хөрш зэргэлдээ орнуудын ижил төстэй зургуудтай уялдуулах замаар Хойд, Төв, Зүүн Азийн чулуулаг бүрхэвчийн зузааны 1: 5000 000-ын масштабын ерөнхий зураг зохиох, Монгол орны мезокайнозойн хотгоруудыг дүүргэсэн хучаас хурдасны зузааны зургийг геологи-геофизикийн мэдээлэл дээр тулгуурлан зохиох, Монгол Алтайн бүс, Монгол-Агнуурын бүсийн зургийг геологи, тектоник, металлогений 1:1000 000-ын масштабтай зургуудыг тоон мэдээллийн хэлбэрээр зохиож хил залгаа нутгийн зургуудтай уялдуулан холбож эцэслэн гаргах ажлууд хийгдэнэ.

Хувийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж буй геологи, хайгуулын ажил

2011.12.01-ний байдлаар Монгол улсын нутаг дэвсгэрт геологи хайгуулын үйл ажиллагаа явуулж буй хайгуулын тусгай зөвшөөрөл 2567 ширхэг байна. Энэ нь нийт газар нутгийн 14,2 % буюу 22,3 сая гектар талбайг хамран геологи хайгуулын үе шатны судалгаа хийгдэж байгаа юм.




2011 онд геологи хайгуулын ажил хийхээр 2430 ш тусгай зөвшөөрлийн талбайд 235,9 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

Өмнөх онуудтай харьцуулахад хайгуулын тусгай зөвшөөрлийн тооноос хамааран бага талбайд төлөвлөлт хийгдэж байгаа хэдий ч зардлын хэмжээ тэр хэмжээгээр буурах биш харьцангуй өсч байна.


Хувийн хөрөнгөөр хийгдсэн геологи хайгуулын ажлын жилийн тайлан ирүүлэлтийн 2007-2011

оны харьцуулалт



2010 оны геологи хайгуулын ажлын тайлан 2675 ширхэг ирүүлсэн нь тайлан ирүүлэх ёстой 2684 тусгай зөвшөөрөлтэй харьцуулахад гүйцэтгэл **99,6%**-д хүрсэн байна. Энэ тоо 2008 онд 87,0%-тай байсан.


**Геологи хайгуулын ажлын төлөвлөгөө ирүүлсэн
2007-2011 онуудын харьцуулалтын байдал**



2011 оны геологи хайгуулын ажлын төлөвлөгөө 2430 ирүүлсэн хүчин төгөлдөр хайгуулын тусгай зөвшөөрлийн тоотой харьцуулахад 90,5 хувьд хүрээд байна.

2010 онд гүйцэтгэсэн геологи хайгуулын хамгийн их зардал гаргасан ажлуудыг үзүүлвэл

2011 оны 11 сарын байдлаар /тэрбум төг, %-иар/




2009 онд хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн өрмийн ажлын дүн 66,8 тэрбум төгрөг байсан бол 2010 онд энэ төрлийн ажилд нийт 101,8 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

Улсын хилээр нэвтрэх шинжилгээний дээжинд тодорхойлолт олгосон байдал

Төрөл	2009	2010			2011			Нийт дээжийн жин, кг	Дээжийн төрөл	Лабораторийн шинжилгээний төрөл	Хэзээ журам батлагдсан
		Эхний хагас	Сүүлийн хагас	Жилээр	Эхний хагас	Сүүлийн хагас	Жилээр				
Компаниуд	57	38	95	133	44	11	55	26309.765	Элс, элсэн чулуу, боржин, туф, аргиллит, базальт, флюорит, хөрзөн, хальцедон, хайрга, усны дээж, хөрсний дээж, чулуун дээж, өрмийн дээж, ургамлын дээж, тунамал ба хүрмэн чулуун дээж, турмалин, шаврын дээж, борооны ус г.м.	геохими, изотоп, петрохими, палеомагнит, геохимийн нас, чулуулгийн нас, агаарын бохирдлыг тодорхойлох, геохимийн нарийвчилсан шинжилгээ, гарал үүслийн шинжилгээ, геологийн нас тодорхойлох, петрографи, соронзон нөлөөг тогтоох шинжилгээ г.м.	Ашигт малтмалын даргын 2009 оны 559 тоот тушаалын хавсралт. Монгол улсын хилээр шинжилгээний дээж нэвтрүүлэхэд тодорхойлолт олгох заавар
Итгэмжлэгдсэн лабораториуд	18	51	20	71	63	2	65	8793.6			
Их дээд сургууль		2	22	24	7	14	21	8233.495			
Эрдэм, шинжилгээний байгууллага		9	27	36	7	15	22	11433.55			
Бусад төрийн болон төрийн бус байгууллага		3	4	7	1		1	307.9			
Бүгд	75	103	168	271	122		164	55078.3	20-оод нэр төрөл	10 гаран нэр төрлийн шинжилгээ	
Нийт	903										

Монгол улсын ашигт малтмалын нөөц болон нөөцийн хөдөлгөөн

Манай улсын ашигт малтмалын нөөц нь 19 төрлөөр бүртгэгдэж нөөцийн хөдөлгөөн жил болгон хийгдэж байна. 2011 оны 01 сарын 01 ны байдалаар улсын нөөцийн хөдөлгөөн доорх байдалтай байна.



Алт шороон ордоор 218,4 тн,
Зэс 82,7 сая тн,

Алт үндсэн ордоор 2 118,4 тн,
Төмөр 253,5 сая тн,

Мөнгө 231,9 мян.тн,
Молибден 874,1 мян.тн

2011 оны нөөцийн хөдөлгөөн


Ашигт малтмалын нөөц 2011 оны 11 дүгээр сарын байдлаар нэмэгдсэн үзүүлэлт

д/д	Ашигт малтмалын төрөл	ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэгдсэн тоо	Нөөц металлаар.тн
1	Алт	23	35,107.32
2	Төмөр	7	28,710,119.39
3	Зэс	4	491,379.74
4	Молибден	3	59,791.10
5	Цагаантугалга	1	656.10
6	Хар тугалга	2	50,559.70
7	Вольфрам	2	1,169.52
8	Хайлуур жонш	16	6,060,458.25
9	Өнгөт чулуу	2	761,938.52
10	Шохойн чулуу	5	14,848,667.47
11	Барилгын чулуу	5	5,011,804.07
12	Нүүрс	24	8.4 тэрбум

Хээрийн шуурхай хяналт

2006-2010 онуудад хийж гүйцэтгэсэн
геологи хайгуулын ажлын
хээрийн шуурхайн хяналтаар газар
дээр нь шалгасан ажлын үзүүлэлт

- Шуурхай хяналтаар явсан тусгай зөвшөөрлийн тоо
- ГХА хийсэн нь батлагдсан
- ГХА хийсэн нь батлагдаагүй



■ Шуурхай хяналтаар явсан тусгай зөвшөөрлийн тоо	199	232	294	241	134
■ ГХА хийсэн нь батлагдсан	177	104	185	157	122
■ ГХА хийсэн нь батлагдаагүй	22	128	109	37	12

ГХА-ын зардлыг газар дээр нь шалган баталгаажуулснаар хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд хийгдэж буй геологи хайгуулын ажлын үнэмшил, бодит үр дүнд шууд нөлөөлдөг.


Дээрх графикаас харахад гүйцэтгэсэн геологи хайгуулын ажил нь газар дээрээ батлагдахгүй тусгай зөвшөөрөл 2008 онд 128, 2009 онд 109 байсан бол 2011 онд 12 болтлоо буурсан байна.



Уул уурхай, судалгааны чиглэлээр.

Хүлээн авсан техник, эдийн засгийн үндэслэл


Монгол Улсад 2011 оны 12 сарын 01-ний байдлаар 682,7 мянган га талбай бүхий 1192 ашиглалтын тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байгаа нь Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 0.4 хувийг эзэлж байна. Эдгээрээс 443 нь орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлтэй байна.



2008-2011 онд нийт 359 ТЭЗҮ-г Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж хүлээн авсан.

Уул уурхайн салбарт хэрэгжих техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаар хэлэлцдэг болсноор хөрөнгө оруулалт, техник технологийн сонголтын тооцоо судалгаа, хүний нөөц ажиллах хүчний судалгаа, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, баяжуулалтын тооцоо, хаягдлын аж ахуй, хоргүйжүүлэлт, төслийн эдийн засгийн хэсгийн үр ашгийн тооцоо, нэгж бүтээгдэхүүний борлуулалтын үнийн сонголт судалгаа, мэдрэмжийн шинжилгээ, хугарлын цэгийг тогтоох зэрэг аргуудыг ашиглан уурхайн эдийн засгийн үр өгөөжийг зөв тодорхойлж байгаль орчин, нөхөн сэргээлтийн ажил болон уурхайн хаалтын төслийг тусгай бүлэг болгон нарийвчлан боловсруулагдаж төслийн үнэ цэнийг нэмэгдүүлсэн гэж үзэж байна.

Уул уурхайн үйлдвэрлэлийн эдийн засагт эзлэх хувь хэмжээ




Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний цэвэр өсөлт 2010 оны байдлаар 6.1%-д байсан ба үүнээс уул уурхайн салбарын цэвэр өсөлт 6.3% -байсан нь бусад салбаруудтай харьцуулахад хамгийн өндөрт тооцогдож байна.

Монгол Улсын экспортын бүтээгдэхүүнд уул уурхайн бүтээгдэхүүний эзлэх хэмжээ жилээс жилд нэмэгдэж байгаа ба 2010 онд өмнөх оны үзүүлэлтээс 3.1% пунктээр нэмэгдсэнээр нийт экспортын 87.7% бүрдүүлж байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт


Манай улс уул уурхайн бүтээгдэхүүний экспортын дийлэнх хэсгийг БНХАУ-руу гаргаж байгаа бөгөөд төмрийн хүдэр, зэс, цайр, цагаан тугалганы баяжмал болон чулуун нүүрсний экспортыг зөвхөн тус улс руу гаргадаг.

Зэсийн баяжмал нь Монгол Улсын экспортын гол бүтээгдэхүүн хэвээрээ байгаа бөгөөд 2010 онд нүүрсний экспортын орлого зэсийн баяжмалын орлогоос анх удаа давсан үзүүлэлттэй гарлаа.




Уул уурхайн салбарт ажиллагсдын судалгаа

Уул уурхайн салбарт 2010 оны байдлаар 210 аж ахуйн нэгжид нийт 48100 хүн ажиллаж байгаа ба энэ нь нийт аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын 32%-ийг эзэлж байгаа юм.



Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчин



Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарт оруулж байгаа хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэхийн хирээр бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдэж байна.

Монголын ашигт малтмалын төслүүдэд хөрөнгө оруулалтыг хийхдээ гадны хөрөнгийн бирж дээр хувьцаа гаргах замаар хөрөнгө татан төвлөрүүлэх хандлага сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. Энэхүү үйл ажиллагааг 50 гаруй компани явуулж байна.

Монгол улсын төсөвт уул уурхайн салбараас оруулж буй орлого


Уул уурхайн салбараас нийт 17 төрлийн татвар, хураамжаар улсын төсөвт орлого төвлөрүүлж байна.

/тэрбум төгрөгөөр/			
	2009	2010	Өсөлтийн хувь
Төвлөрүүлсэн орлого	486.8	819.4	+68.3%

Уул уурхайн салбарын татварын орчин

Татварын ачааллын хэмжээ 2007 онд 37%, 2008 онд 25% , 2009 онд 23% болж буурсан бол 2010 онд 41% болж өссөн байна.

Уул уурхайн салбарын татварын ачаалал



2008 оны 11 сарын 25-ны өдрийн зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын хуулиар өөрчлөлт орж алтны босго үнийг 1 унци алтны үнэ 850 ам доллар болж өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 2009 онд татварын ачаалал буурсан ба ихэнх алтны олборлогч аж ахуйн нэгжийн монгол банкинд тушаах алтны хэмжээ багассан.

Энэ татвар 2010 онд хүчингүй болсон боловч Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 3.3-д заасан нэмж ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийн хувь хэмжээг тогтоосноор татварын ачаалал 41% болж өссөн байна.

Байгаль орчны нөхөн сэргээлт

Үзүүлэлт	х/н	2007	2008	2009	2010	2011 төлөвлөгөө
Уурхайн эдэлбэр	мян.га	31234.2	31428.5	32 135.7	32 686.7	33 976.7
Уулын ажилд хамрагдсан талбай	га	1 184.1	707.3	558.3	1 046.6	1 290.9
Нөхөн сэргээсэн талбай	га	1 354.5	927.7	703.4	786.5	1 210.6
Нөхөн сэргээлтэнд зарцуулсан хөрөнгө	сая.төг	9 189.9	7 676.5	4 146.5	4 219.7	6 015.43

Ашигт малтмалын тухай хууль 2006 онд шинэчлэн батлагдан гарснаас хойш ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үүрэг хариуцлага нэмэгдэн хуулийн дагуу нөхөн сэргээлтийн ажлаа төлөвлөн, цаг хугацаанд нь нөхөн сэргээлт хийх ажлууд сайжирч байгаа нь сайшаалтай байна.

2011 онд орхигдсон газрын тооллогыг 20 аймгийн **699** нэгж талбайд, нийт **4256 га** талбайд хийлээ.

Хийж гүйцэтгэсэн ажлууд

- Стратегийн ордод хамааруулах шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулсан;
- Стратегийн ач холбогдол бүхий 12 ордын хил хязгаарыг тогтоох санал, ашигт малтмалын ордыг стратегийн ач холбогдолтой эсэхийг үнэлэх санал боловсруулах журам, заавар;
- БНСУ-ын “Миреко” байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй бохирдолд орсон газрын судалгаа хийх, мэдээллийн сан үүсгэх төслийн хүрээнд хээрийн судалгааны ажлыг 2011 оны 5-р сараас эхлэн Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Увс, Ховд, Баян-Өлгий, Завхан, Булган, Говь-Алтай аймгуудын төлөвлөсөн **199** нэгж талбарт хэмжилт зураглал, судалгааны ажил хийж хөрсний-912, усны-141 дээж авч лабораторид боловсруулахад бэлэн болгоод байна.
- “Ашигт малтмалын тухай” хуулийн 23 дугаар зүйлийг үндэслэн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч **38** аж ахуйн нэгжтэй Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээг байгуулан ажиллаж байна.
- Нөөцгүй, ашиглалтын тусгай зөвшөөрлийн шаардлага хангахгүй 36 тусгай зөвшөөрлийг цуцалсан.

Хийж гүйцэтгэсэн ажлууд

- “Ашигт малтмалын тухай” хуулийн 48.6 дахь заалтын дагуу нийт 1187 ашиглалтын тусгай зөвшөөрөл байгаагаас 443 нь орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлтэй байна. Үүнээс: 2008-2011 онд 359 нийт Техник эдийн засгийн үндэслэл Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж хүлээн авсан.
- Далд уурхайн хаалт, техникийн шаардлага”, “Уурхайн хаалтын нөхөн сэргээлтийн стандарт, “Ашигт малтмалыг нуруулдан болон овоолон уусгах үйлдвэрийн хаалт, техникийн ерөнхий шаардлага” стандартуудыг бэлтгэн батлуулахад бэлэн болоод байна,
- Ашиглалтын нийт тусгай зөвшөөрлийн хүрээнд нэгдсэн мэдээллийн сан үүсгэж (катологи) –ийг боловсруулж нөөцийн асуудлыг МХЕГ-т тавьж шийдвэрлүүлсэн бөгөөд цаашид мэдээллийн баазыг өргөжүүлэхээр ажиллаж байна.
- *Уул уурхайн салбарын судалгааны ажлууд*
- Зэс, алт, мөнгөний зах зээлийн орчны судалгааны ажлуудыг хийж гүйцэтгээд байна,
- Салбарын хөрөнгө оруулалтын зах зээлийн талаар судалгааг гүйцэтгэлээ
- Татвар эрх зүйн орчны судалгааг шинэчлэн боловсруулав

Хийж гүйцэтгэсэн ажлууд


- “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн хэрэгжилттэй холбоотой тооцоо судалгаа, суурь мэдээллүүдийг тухай бүр түргэн шуурхайн боловсуулан яам, аж ахуйн нэгжүүд, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангаж ажиллаж байна. Одоогийн байдлаар нөхөх олговрыг тооцох ажлыг гүйцэтгэж байна.
- “Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор” байгуулах төслийн зөвлөх АНУ-ын “Бехтел” компанитай, Японы төмөрлөгийн үйлдвэрлэлийн “Кобэ стийл” корпораци, ЭБЭХЯ хооронд хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хамтран ажиллах бэлтгэл ажлууд болон суурь судалгааны ажилд хамтран ажиллаж байна.
- Монгол-Энэтхэгийн хамтын ажиллагааны хамтарсан хорооны, БНХАУ-ын Засгийн газар хоорондын эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны комиссын, “Технологи-ITMK 3” технологи ашиглан төмрийн хүдэр боловсруулах боломжийг судалж дүгнэлт гаргахаар ажилласан

Уул уурхай судалгааны хэлтсээс зохион байгуулсан хурал зөвлөлгөөн

- “Metals Mongolia” чуулга уулзалтыг ЭБЭХЯ, “Инфо майн” тай хамтран,
- “Уул уурхайн салбар-хөгжлийн тулгуур сэдэвт онол-практикийн бага хурал,
- Цахим хэлбэрээр мэдээ тайлан хүлээн авах ажлын сургалт,
- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлан гаргах сургалт,
- Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн хэрэгжилт сэдэвт нээлттэй хурал, семинар,
- Уул уурхайн аврах албаны 60 жилийн ойн арга хэмжээний хүрээнд “Уурхайн аваари устгах төлөвлөгөөг боловсруулах аргачилал, аврах ажиллагааны үзүүлэх сургалт”,
- “Техник эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба ТЭЗҮ хүлээн авах заавар”-тай холбогдуулан ТЭЗҮ боловсруулагч байгууллага болон эрдэм шинжилгээний байгууллага, зөвлөх инженер, салбарын эрдэмтэд, докторууд оролцсон зөвлөлгөөнийг зохион байгуулав.
- Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Ашигт малтмалын газар, АНУ-ын Азийн сан хамтран “УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА” сэдэвт зөвлөгөөнийг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж, оролцов.
- “Бичил уурхайн холбогдолтой хууль, тогтоомжийн хэрэгжилт” сэдэвт үндэсний форум, зөвлөгөөнийг зохион байгуулсан.
- “Бичил уурхайгаар ашигт малтмалын олборлосон газрыг нөхөн сэргээх, дундын сан бүрдүүлэх” сэдэвт сургалт семинар

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын албатай хамтран ажиллах

Ашигт малтмалын газар ОҮИТБС-ын ажлын албатай хамтран 2007-2011 онд нийтдээ Олборлох үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд ОҮИТБС-ын мэдээ тайлан гаргах арга зүйн зөвлөгөө өгөх 20 удаагийн сургалт хийсэн бөгөөд нийтдээ 2000 гаруй аж ахуйн нэгжүүдийг сургалтанд хамруулаад байна.



■ Тайлан гаргасан ААН-н тоо

Уулын ажлын төлөвлөгөө, тайланг цахим хэлбэрээр хүлээн авах




Уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс ирүүлдэг уулын ажлын тайлан төлөвлөгөөг хүлээн авах ажлыг хөнгөвчлөх, төрийн үйлчилгээг шуурхай үзүүлэх зорилгоор цахим хэлбэрээр мэдээ тайланг хүлээн авах ажлыг эхлүүлэн хэрэгжүүлж эхлээд байна. Өнөөдрийн байдлаар 40 гаруй аж ахуйн нэгжүүд электрон хэлбэрээр тайлан мэдээгээ ирүүлээд байна.

Бичил уурхай

- 2011 оны байдлаар нийт 16 аймаг, Улаанбаатар хотын 1 дүүрэгт 61000 гаруй хувиараа ашигт малтмал олборлогчид ажиллаж байна. Хувиараа ашигт малтмал олборлогчдын 98.4 хувь нь алтны үндсэн ба шороон орд, 0.38 хувь нь гянтболдын орд, 0.71 хувь нь жоншны орд, 0.28 хувь нь нүүрсний орд, 0.14 хувь нь цагаан тугалганы орд, 0.04 хувь нь давсны орд дээр тус тус олборлолт явуулж байна.
- Бичил уурхайчид 2011 оны 10 дугаар сарын байдлаар 59 484 350 төгрөгийн татвар улсад төлж, нөхөн сэргээлтийн санд 46 797 025 төгрөг төвлөрүүлээд байна.
- Нийт 2274 бичил уурхайн ажиллагсад бүртгэлд хамрагдаад байгаагийн 1308 хүн эрүүл мэндийн даатгалд, 1005 хүн нийгмийн даатгалд хамрагдаад байна.
- Бид 60 гаруй мянган байнгын болон түр ажлын байр бий болгож буй бичил уурхайчдад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор 57 удаагийн сургалт, семинар зохион байгуулан, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарч ажиллалаа.

Бичил уурхай



Өнөөдрийн байдлаар 7 аймгийн 17 сумын нутагт бичил уурхайн зориулалтаар нийт 53 газрыг ашиглахаар 31 хүсэлт ирүүлснээс 25 газарт нь зөвшөөрөл олгогдсон байна.



Нүүрс судалгааны чиглэлээр.

“МОНГОЛ НҮҮРС” хөтөлбөр


- Улсын төсвийн тодорхой хувийг нүүрсний аж үйлдвэрийн салбараас бүрдүүлж ирсэн бөгөөд энэ нь жил бүр өсөн нэмэгдэж байгаа нь энэхүү хөтөлбөрийг боловсруулан батлуулан хэрэгжүүлэх үндсэн шаардлага болж байгаа бөгөөд нөгөө талаасаа нүүрсний нөөц баялгийг өсгөх геологи судалгааны ажлуудыг нэмэгдүүлэх, боловсруулан ашиглаж, эдийн засгийн аюулгүй байдлаа бататгах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаагийн дээр манай улсын хэмжээнд хүн ам олноор төвлөрсөн суурин газруудад түүхий нүүрсийг хэрэглэснээр агаарын бохирдлыг ихэсгэх нэг гол хүчин зүйл болж байгаа нь экологийн цэвэр түлшний үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.
- “**Монгол Нүүрс**” хөтөлбөр нь нүүрс олборлолтыг нэмэгдүүлэх, нүүрснээс шатдаг хий, шингэн түлш гарган авах, эрчим хүч үйлдвэрлэх нүүрсний цэвэр технологи, нүүрс боловсруулах, кокс-хими болон нүүрс-химийн үйлдвэрлэлийг цогцоор нь хөгжүүлэх чиглэл, бодлогыг тодорхойлсон Монгол улсын эдийн засгийн хөгжлийг түргэтгэх стратегийн тулгуур баримт бичиг болно.
- Уг хөтөлбөрийн төслийг боловсруулсан батлуулахаар ажиллаж байна.

Нүүрсний нөөц

Манай улсын нүүрсний геологийн таамаг нөөц 163,2 тэрбум тонн, цаашдаа өсгөх магадлалтай гэж тогтоосон бөгөөд 20 гаруй тэрбум тонн нүүрсний нөөцийг урьдчилсан болон нарийвчилсан хайгуулын үр дүнгээр тогтоосон 15 сав газрын хүрээнд 300 гаруй орд, илрэл байгаа бөгөөд манай орон нүүрсний нөөцөөр дэлхийн эхний 10 орны тоонд багтдаг.



Монгол улсын нүүрсний олборлолт экспорт (МЯН.ТОНН)



2010 онд 25,296 сая тонн нүүрс олборлон 18,241 сая тонн нүүрс экспортод гаргасан бөгөөд 2009 онтой харьцуулахад олборлолт 191%, экспортод гаргасан нүүрс 241% буюу 2,4 дахин өссөн үзүүлэлттэй байна.

2011 оны эхний 10 сарын байдлаар 25,814 сая тонн нүүрс олборлож, 18,141 сая тонн нүүрс экспортод гаргасан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал олборлолт 136,7%, экспорт 139,3% -иар тус тус өссөн харагдаж байна.

Нүүрсний салбарын эдийн засаг

Нүүрсний салбараас улсын төсөвт төлөрүүлсэн орлого:


/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2009 оны гүйцэтгэл	2010 оны гүйцэтгэл	2011 оны төлөвлөгөө
Улсын төсөвт	90.8	248.1	295.2
Нөөц ашигласны төлбөрт	25.6	63.3	102.0
ААН-ийн ОА татварт	33.7	107.1	110.7
Бусад	31.5	77.7	82.5
Нийт	181.6	496.2	590.4

Манай улсын нүүрсний экспорт эрчимтэй өсөж байгаа нь Хятад улсын нүүрсний эрэлт хэрэгцээ нэмэгдэж, Австрали улсын нүүрсний экспортын бууралт зэрэг хүчин зүйлсийн нөлөөлөл байгаа бөгөөд цаашид ч их хэмжээгээр нэмэгдэх хандлагатай байна.

Нүүрсний үнийг чөлөөлөх

Монгол Улсын газар нутаг том, дэд бүтцийн сул хөгжсөн зэрэг шалтгааны улмаас дотоодын зах зээлийн хувьд өрсөлдөөний нөхцөл хязгаарлагдмал, нүүрсний үнэ чөлөөт бус төрийн зохицуулалттай байдаг. Түлш, эрчим хүчний үнийг бодит өртөгт нь хүргэн нэмэгдүүлэх асуудлыг үе шаттайгаар хэрэгжүүлэхийн зэрэгцээ тодорхой хугацаанд үнэ нэмэгдүүлэх бодит хүчин зүйлийн нөлөөллийг саармагжуулан ард түмний амьдралын түвшин, төлбөрийн чадвар сайжрах хүртэл ачааллын зарим хэсгийг улсын төсвийн татаасаар санхүүжүүлэх замаар асуудлыг авч үзэх шаардлагатай болж байдаг.



Нүүрсний салбарын техник, технологийн өнөөгийн түвшин



Нүүрсний уурхайнуудад ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийн 20% нь ОХУ буюу хуучнаар ЗХУ-д үйлдвэрлэгдсэн, 80 гаруй хувь нь АНУ-ын “Caterpillar”, Японы “Komatsu”, Германы “Liebherr”, Солонгосын “Hyundai”, БНХАУ-ын техникүүд ажиллаж байна.

Нүүрсний аж үйлдвэрийн салбарт ажиллаж байгаа аж ахуйн нэгжийн төлөөллүүдээс “Энержи ресурс” ХХК, “Монголын Алт МАК” ХХК, “Саус Гоби Сэндс” ХХК, “МОЭНКО” ХХК-ууд нь орчин үеийн дэвшилтэд техник технологээр үйлдвэрлэлээ явуулж байгаа бөгөөд Ухаа худагийн уурхай шинэ шийдэл бүхий цогцолборыг бүтээн байгуулж байгаагаас гадна Шивээ-Овоогийн уурхай “Нүүрсний чийглэгийг бууруулах, конвейерийн тээврийн систем нэвтрүүлэх” шинэ төслийг хэрэгжүүлж байна.

Нүүрсний боловсруулах үйлдвэрүүд

Монгол орны хэмжээнд одоогийн байдлаар үйл ажиллагаа нь албан ёсоор явагдаж буй нүүрсний гүн боловсруулалтын 3 үйлдвэр, барилга угсралтын шатандаа яваа 1 үйлдвэр, судалгаа, шинжилгээ, баримт бичгийн боловсруулалтын шатандаа явж байгаа 2 төсөл хэрэгжихээр төлөвлөгдөн ажиллаж байна.

№	Аж ахуйн нэгж	Бүтээгдэхүүний нэр	Хүчин чадал
1	“Энержи ресурс” ХХК	Баяжуулсан нүүрс	15.000.000 тн
2	“НАКО Түлш” ХК	Хагас коксон шахмал түлш	60.000 тн
3	“МАК” ХХК	Хагас кокс	75.000 тн
4	“АМОРЕ Интернэйшнл” ХХК	Хагас коксон утаагүй шахмал түлш	210.000 тн

Эдгээр үйлдвэрүүдээс “Энержи ресурс” ХХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэр 2011 оны 6-р сард ашиглалтанд орж улсын комисс хүлээн авсан бол “МАК” ХХК, “Нако түлш” ХК-ийн хагас коксын үйлдвэрүүд 2011 оны 11-р сард Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн хурлаар Техник-эдийн засгийн үндсэлэлээ батлуулсан.

Хийж гүйцэтгэсэн ажлууд

1. СУДАЛГААНЫ АЖЛУУД:

“Нүүрсний хийжүүлэлт, давхаргын метан хийн судалгаа”

“Хагас коксжуулалт, коксжуулалтын судалгаа”

“Нүүрс баяжуулах орчин үеийн технологиуд”

“Нүүрсний шингэрүүлэлтийн тойм судалгаа, технологийн сонголт”

“Нүүрсний демпинг үнийг хязгаарлах судалгаа”

2. Нүүрсийг боловсруулж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлэх суурь үндэс болсон нүүрсний бүтээгдэхүүний стандартуудыг боловсруулж, батлуулав.

MNS 5679 : 2011 “Шахмал түлш. Техникийн ерөнхий шаардлага”

MNS 5679.1 : 2011 “Хагас коксон түлш. Техникийн ерөнхий шаардлага”

MNS 6226 : 2011 “Баяжуулсан нүүрс. Техникийн ерөнхий шаардлага”

3. Нүүрсний туршилт, шинжилгээний лаборатори магадлан итгэмжлэгдлээ.

4. Уг лабораторид шинэ техник технологи, аргачлал нэвтэрч, 2011 оны 12 сард 200 гаруй дээжинд шинжилгээ хийн 14,5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хийж гүйцэтгэсэн ажлууд


- Монгол орны нүүрсний стратегийн ордуудын тодорхойлолтыг гаргаж, ЭБЭХЯ-нд хүргүүлэв.
- Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах талаар Засгийн газрын гаргасан тогтоолын хэрэгжилтийг бүрэн ханган ажиллав.
- Нүүрсний аж үйлдвэрийн салбарын ээлжит IV зөвлөлгөөнийг зохион байгуулж, хэлэлцсэн асуудлаар эмхэтгэл гаргалаа.
- НСХ-ийн Нүүрсний туршилт, шинжилгээний лабораторийн ахлах шинжээч, химийн ухааны доктор Ж.Нарангэрэлийн “Нүүрсний хими, технологийн үндэс” ном хэвлэгдэн гарлаа.
- Монгол-Германы засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу баригдах нүүрс шингэрүүлэх үйлдвэр байгуулах талаар ажлын хэсэгт ажиллан санал өгөв.
- Шивээ-Овоогийн нүүрс хатаах, конвейерийн тээвэрлэлтийн цогцолбор үйлдвэрийг ашиглалтанд хүлээн авах техникийн, улсын комисст ажиллан, техник технологит үнэлэлт, дүгнэлт өглөө.
- Хилийн “Гашуунсухайт”, “Шивээхүрэн” боомтын нэвтрэх чадварыг сайжруулахад анхаарч, аж ахуй нэгжүүд өөрийн хүч, хөрөнгөөр нэвтрэх гарцыг хатуу хучилттай зам болгоход дэмжиж ажилласнаар 2011 оны 12 сарын 1-ний байдлаар 21.5 сая.тн нүүрс экспортод гарсан байна. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад олборлолт 117%, экспорт 118%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нүүрс олборлогч аж ахуйн нэгжийн уулын ажлын тайлан, төлөвлөгөө

№	Уурхайн төрөл	2009 оны УА-ын тайлан		2010 оны УА-ын тайлан		2011 оны УА-ын төлөвлөгөө	
		ирүүлсэн	баталсан	ирүүлсэн	баталсан	ирүүлсэн	баталсан
1	Эрчим хүчний нүүрс	3	3	6	5	6	6
2	Орон нутаг, ахуйн хэрэглээний нүүрс	17	15	25	19	32	25
3	Экспортын нүүрс	12	11	13	13	13	13
	Д ү н	32	29	44	37	51	44

ЭБМЗ-өөр батлагдсан нүүрсний орд

Нүүрсний оруудын Геологийн фондод хадгалагдаж байгаа 1932-2011 оны нийт 206 нөөцийн хуралдаануудын протокол, 99 ордын 197 геологи хайгуулын ажлын тайлан, 1990 он, 2004 оны нүүрсний баланс, бичмэл мэдээллийн хэсгийн нүүрсний ордын мэдээллийн хэмжээнд боловсруулалт хийсэн.






Кадастрын бүртгэлийн чиглэлээр.


Ашигт малтмалын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл

2011 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар нийтдээ 23,0 сая га талбайг хамарсан ашигт малтмалын 3765 тусгай зөвшөөрөл, үүнээс 682,9 мянган га талбай бүхий 1196 ашиглалтын тусгай зөвшөөрөл, 22,3 сая га талбай бүхий 2569 хайгуулын тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 0.4 хувийг ашиглалтын, 14,2 хувийг хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбай эзэлж, нийт нутгийн 14,6 хувьд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна.


Ашигт малтмалын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо, 2008-2011



Хүчин төгөлдөр талбайн хэмжээ, сая гектар, 2008-2011 он




Нийт тусгай зөвшөөрөлтэй талбайн Монгол улсын нутаг дэвсгэрт эзлэх хувь, 2008-2011



Тусгай зөвшөөрөлтэй талбай 2009 оны эцэст Монгол улсын нийт газар нутгийн 25,2%-ийг эзэлж байсан бол өнөөдөр 14,6% болж, 10,6%-иар буурсан байна.

Дээрх тусгай зөвшөөрлийн тоо болон талбайн хэмжээний үзүүлэлтүүд бол 2006 онд АМТХ шинэчлэн батлагдсанаас хойших хугацаанд байгаагүй түүхэн бага үзүүлэлт юм.

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн бүтэц, ашигт малтмалын төрлөөр, 2011.XII.21



Ашигт малтмалын ашиглалтын 1196 тусгай зөвшөөрлийн дийлэнхи буюу 38,0 хувь нь алт олборлох тусгай зөвшөөрөл бол нийт ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 682,9 мянган га талбайн 47,6 хувь нь нүүрс олборлох талбай байна.


Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын бүтэц

ААН-ийн төрөл	Эзэмшигч		Тусгай зөвшөөрөл		Талбай	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Сая гектар	Хувь
Улсын хэмжээнд	1836	100.0	3765	100.0	23.0	100.0
Дотоодын	1400	76.3	2582	68.6	12.5	54.3
Гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай	291	15.8	842	22.4	8.5	37.0
Хамтарсан хөрөнгө оруулалттай	145	7.9	341	9.1	2.0	8.7

2011.12.21-ний байдлаар 1836 аж ахуйн нэгж байгууллага 3765 тусгай зөвшөөрлийг эзэмшиж байгаа ба үүний 68,6 хувийг дотоодын аж ахуйн нэгж, 31,2 хувийг гадаадын хөрөнгө оруулалттай компани, аж ахуйн нэгж эзэмшиж байна. Нийт 1836 эзэмшигчийн 76,3 хувь нь дотоодын аж ахуйн нэгжүүд 23,7 хувь нь гадаадын аж ахуйн нэгж байгууллага байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн дийлэнхи хувийг БНХАУ, Виржиний арлууд, Өмнөд Солонгос, ОХУ-ын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд эзэлж байна.

Шинээр олгосон болон талбай хураагдсан, хөдөлгөөнд орсон тусгай зөвшөөрлийн тоо, 2009-2011 он



2011.12.21-ний байдлаар ашигт малтмалын нийт 106 тусгай зөвшөөрөл /ашиглалтын/ хүссэн өргөдлийг шийдвэрлэсэн ба үүнээс 77 өргөдөлд олгох, 29 өргөдөлд татгалзах шийдвэр гаргасан байна. АМТХ-ийн хэрэгжилтийг чангатгаж, хууль хэрэгжүүлдэггүй тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай хариуцлага тооцож тусгай зөвшөөрлийг нь цуцлах, дуусгавар болгох, талбайг нь буцааж авах замаар 2009-2011 онуудад нийтдээ 2617 тусгай зөвшөөрлийн эрхийг хүчингүй болгосон байна.

Бүртгэлтэй талбай

2011.12.21.

Д/д	Талбайн нэр	Талбайн тоо	Талбайн хэмжээ /сая га/	Хувь
1	Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй талбай	3765	23.0	14.6%
2	Сонгон шалгаруулалтын талбай	4042	37.7	24.0%
3	Геологийн талбай	56	5.2	3.3%
4	УТХГС хийсэн талбай	1268	40.3	25.8%
5	Стратегийн орд газар	22	0.08	0.05%
6	Улсын тусгай хамгаалалттай газар	101	27.2	17.4%
7	Тусгай хэрэгцээний газар	1187	44.8	28.3%
8	Засгийн газрын нөөцөд авсан талбай	45	12.6	8.0%
9	Эдэлбэр газар	385	1.0	0.6%
10	Цөмийн энергийн газарт бүртгэсэн талбай	153	3.8	2.4%
11	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газар /ЗГ-ын 2011оны 174-р тогтоол/	341	0.04	0.03%


Хийж гүйцэтгэсэн ажлууд

- Орон нутгийн тусгай хэрэгцээний нийт 301,7 мян.га 28 бүхий талбай, Улсын тусгай хамгаалалтад эрх бүхий байгууллагаас авсан 4 286,3 мян.га бүхий 11 талбайг ГУУК-т шинээр бүртгэсэн.
- Кадастрын бүртгэлийн системийг бүрэн автоматжуулах төслийг үргэлжлүүлэн, тусгай зөвшөөрлийн 2010 оны IV сараас өмнөх түүхэн мэдээллийг системд нөхөн оруулах ажлыг эхлүүлсэн, гүйцэтгэл 50 орчим хувьтай.
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн шинэчилсэн бүртгэлийг зохион байгуулж байна. XII/21-ний байдлаар бүртгэлтэй байгаа 1867 хуулийн этгээдийн 624 нь уг бүртгэлд хамрагдаад байна.
- “Хилийн заагийг хэсэгчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2011 оны 174 дүгээр тогтоолын дагуу гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хилийн заагийн 242 тусгай зөвшөөрөлд холбогдох 5284 солбицлоор тодорхойлогдсон 341 талбайг системд бүртгэсэн. Энэ нь нийт нутаг дэвсгэрийн 0.03% эзэлж байна.
- 13 аймгийн 1187 орон нутгийн тусгай хэрэгцээний газрын судалгааг хийлээ. Судалгааны дүнгээр 507 тусгай хэрэгцээний газартай давхцалтай 442 тусгай зөвшөөрөл, өөр хоорондоо давхцалтай 205 тусгай хэрэгцээний талбай байгаа нь тогтоогдлоо. Энэхүү судалгааны дүнд үндэслэн тусгай зөвшөөрлөөр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон газрын бүртгэлийг цэгцлэх асуудлаар удирдах дээд байгууллагуудад санал хүргүүлсэн.



Захиргаа удирдлагын чиглэлээр.

Архив, бичиг хэргийн эргэлт



Хүний нөөцийн удирдлагаар хангах


- “Сургалтын хөтөлбөр”-ийн дагуу 2011 оны сургалтын төлөвлөгөөг батлуулсан.
- “Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд ажиллаж байна.

Шагнал, сургалт, тусламжийн хэмжээ мөнгөн дүнгээр:



Хүний нөөцийн удирдлагаар хангах

Шагнал, сургалт, тусламжийн хэмжээ хүний тоогоор:



2011 онд 85 албан хаагчид нэг удаагийн тусламж, тэтгэлэг олгосон бөгөөд дотоод сургалтад 69, гадаад сургалтад 44 албан хаагчийг хамруулсан.

Алтан гадас одонгоор 3, Хөдөлмөрийн хүндэт медалиар 5, яамны жуух бичгээр болон салбарын тэргүүнээр 8 ажилтан шагнуулсан ба Ардын хувьсгалын 90 жилийн ойн медалиар 200 ажилтан албан хаагч, ахмадуудыг шагнууллаа.

2011 оны ажлын үр дүнгээр 14 ажилтныг гадаадад аялуулахаар шийдвэрлээд байна.

Агентлагийн дотоод журам зөрчсөн, ажлын хариуцлага алдсан 1 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Агентлагийн нээлттэй байдлыг хангах

- Лавлагаа мэдээллийн төвийг нээлттэй утас /263678/-тайгаар ажиллуулж байна.
- Хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд, өдөр тутмын сонинд мэдээ мэдээлэл тогтмол нийтлүүлж байна.
- Нээлттэй хаалганы өдөр, Ашигт малтмалын тухай хуульд ард нийтээс санал авах зэрэг ажлуудын зохион байгуулсан.
- Сэтгүүлчдийг 5, 10 дугаар саруудад урьж мэдээлэл хийн, нээлттэй ярилцлага явуулсан.
- Агентлагийн үйл ажиллагааг харуулсан “Эрдэс баялгийн шинэ мэдээ” сэтгүүлийн тусгай дугаар хэвлүүлсэн.

Гадаад харилцаа, хамтын ажиллагаа



зэрэг байгууллагуудтай нийт 10 харилцан ойлголцох санамж бичиг байгуулан хамтран ажиллаж байна.

❖ БНСУ-ын Гео шинжлэх ухаан, эрдэс баялагийн хүрээлэн (KIGAM), Япон улсын Шинжлэх ухаан, технологийн аж үйлдвэрийн улсын хүрээлэн (AIST), БНСУ-ын Уул уурхайн нөхөн сэргээлтийн корпораци (MIRECO), Япон улсын газрын тос, байгалийн хий, металлын үндэсний корпораци (JOGMEC), ХБНГУ-ын Лаусицер Миттелдойч нөхөн сэргээлтийн компани (LMBV), ХБНГУ-ын Гео шинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэн (BGR)

- ❖ Геологи, уул уурхайн судалгааны чиглэлээр “Зүүнговийн районы нүүрсний хамтарсан судалгаа” төсөл, “Геомэдээллийн сан бүрэлдүүлэх төсөл”, 1:200000-ны масштабтай Улсын геологийн зураг зохиох төсөл болон сэдэвчилсэн судалгааны ажлууд, “Төв Монголын хүдрийн бүсэд хамтарсан судалгаа гүйцэтгэх төсөл”, “Тогтвортой бичил уурхайн төсөл”, “Байгаль орчны бохирдлын судалгаа хийх төсөл”, “Уул уурхайн институцийг бэхжүүлэх техникийн туслалцааны төсөл” зэрэг нийт 10 төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

Хийж гүйцэтгэсэн ажлууд

- ❖ Ажилтан албан хаагчдын нэгдэл нягтралыг сайжруулах, эвсэг нийтэч хамт олон бүрдүүлэх зорилгоор Баасан гариг бүрийн өглөө мэдээллийн цаг арга хэмжээг зохион байгуулж, ажилтнуудын сонирхсон сэдвээр олон нийтэд алдартай хүмүүсийг урьж сонирхолтой ярилцлагыг явуулах, байгууллагын цасны баяр, спортын аварга шалгаруулах тэмцээн, Монгол орны байгалийн үзэсгэлэнт газруудад аялал зохион байгуулах зэрэг олон нийтийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж байна.
- ❖ “Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд 2009-2011 онд нийт 56 албан хаагчид түлээ нүүрсний хөнгөлөлт үзүүлж, 2 ажилтныг төрийн албан хаагчийн орон сууцны квотод хамрууллаа.
- ❖ Орон сууцны зээлд хамрагдах хүсэлт гаргасан ажилтнуудыг дэмжих зорилгоор “Голомт” банктай хөнгөлөлттэй зээлийн гэрээ байгуулсан. Уг зээлийн нөхцлөөр 12 ажилтан Баянмонгол хороололд орон сууцтай болсон байна.
- ❖ Агентлагийн 14 албан хаагчид орон сууцны дэмжлэг болгож тодорхой мөнгөн тусламж олгох асуудлыг шийдвэрлэсэн.


Хууль, эрх зүйн орчныг сайжруулах

- Монгол улсын ашигт малтмалын салбарын эрх зүйн нэгдсэн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгын хүрээнд Ашигт малтмалын тухай хуулийг олон улсын жишигт хүргэн сайжруулсан хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгууллаа.
- Агентлагийн “Ёс зүйн хороо” байгуулах тухай эрх зүйн баримт бичиг гаргаж 2011.03.22-ны өдрийн 91 тоот тушаалаар батлуулсан.
- “Тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааны заавар”-ыг шинэчлэн 2011 оны 06 дугаар сарын 9-ны өдрийн 250 дугаар тушаалаар батлуулсан.
- “Ашиглалтын өмнөх гэрээ байгуулах үйл ажиллагааг хянах дотоод хяналтын хуудас”-ыг боловсруулж АМГ-ын даргын 2011 оны 503 дугаар тушаалаар батлуулсан.
- “Ашигт малтмалын газрын төрийн үйлчилгээний албан хаагчдад мэргэжлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох тухай журам”, “Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд гүйцэтгэх хайгуулын ажлын зардлын доод хэмжээг баталгаажуулах тухай заавар” зэргийг шинэчлэн боловсруулж Агентлагийн даргын тушаалаар батлуулан агентлагийн хэмжээнд дагаж мөрдөж байна.
- Тусгай зөвшөөрлийн эрхийг хүчингүй болгосон, цуцалсан, дуусгавар болгосон нийт 1024 тусгай зөвшөөрлийн 80 буюу 7.8 хувь нь шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо 0.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Авлигын эсрэг үйл ажиллагаа


- Авлигын эсрэг хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн газрын 24 дүгээр хуралдааны тэмдэглэлийг хэрэгжүүлэх зорилгоор “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2011 оны төлөвлөгөө”-ний биелэлтийг гарган Авлигтай тэмцэх газар болон Засгийн газрын хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлсэн.
- Засгийн газрын хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан Азийн сангаас хэрэгжүүлж байгаа Монгол Улсад Авлигатай тэмцэхэд зориулсан үйл ажиллагааны хаалтын ажиллагаа сэдэвт семинарт оролцсон.
- Авлигатай тэмцэх газрын даргын 2010 оны 02 тоот тушаалаар “Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн загвар маягт” /ХОМ2/ болон тайлан /ХОМ-1/-г Ашигт малтмалын газрын төрийн захиргааны албан тушаалтнуудын 2009 оны хөрөнгө, орлогын мэдүүлэг /хураангуй/-ийг 2011 оны 02 дугаар сарын 15-ны байдлаар бүрэн хамруулан хүргүүлсэн.

Төсвийн орлогын гүйцэтгэл(сая.төг)



2010 онд улсын улсын төсвийн орлогыг 114,1%-иар биелүүлсэн бол энэ 2011 оны хүлээгдэж буй гүйцэтгэл 121,7%-тай байна.

Батлагдсан зардлын гүйцэтгэл (сая.төг)



Батлагдсан зардлыг 2009 онд 203,9 сая, 2010 онд 17,0 сая, 2011 онд 169,3 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ:

- ❖ Ажилтнуудын 14 хоног тутмын ажлын тайлан;
- ❖ Үйлчлүүлэгч болон нийт албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч дүгнэсэн;
- ❖ Батлагдсан удирдамжийн дагуу 6 удаагийн дотоод хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн;
- ❖ Орон тоо, бүтэц шинэчлэхтэй холбогдуулан нийт ажилтнуудын ажлын байрны зураг авалт хийн, зөвлөмж гаргасан;
- ❖ Агентлагийн веб хуудсанд 7 хоног бүр мэдээ, мэдээллийг хянан оруулж ажилласан;



3. Цаашдын зорилтууд

Цаашид хийж гүйцэтгэх ажил, баримтлах бодлого

- Монгол улсын ашигт малтмалын нөөц, баялагийг үр өгөөжтэй, гүйцэд ашиглах нөхцлийг хангах түүнчлэн хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмалын нөөц, баялгийн тайлагналыг боловсронгуй болгох үүднээс олон улсын ашигт малтмалын нөөцийг тайлагнах олон улсын стандартын хороотой хамтран ажиллах.
- Монгол орны нутаг дэвсгэрт хувийн хөрөнгөөр хайгуулын ажил хийж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын жил болгон ирүүлэх тайлан төлөвлөгөөг цахим хэлбэрээр авдаг болох.
- Хуулийн хэрэгжилт, хайгуулын ажлын бодит байдлыг хангах үүднээс газар дээр нь шалгах боломжгүй топо ажил, геохими, геофизик, лабораторын шинжилгээ гэх мэт ажлуудыг шалган баталгаажуулдаг болох.
- Хайгуулын тусгай зөвшөөрөлийн талбайд сүүлийн 3 жилд хийгдсэн ажлын үр дүн болон шинээр нээгдсэн орд газаруудын байршил болон бусад мэдээллийн талаарх 1:1000 000 масштабтай ашигт малтмалын нэгдсэн зураг гаргах.

Цаашид хийж гүйцэтгэх ажил, баримтлах бодлого

- Баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийг дэмжих, дэвшилтэт технологийг судлах, нэвтрүүлэх;
- Нөөцгүй ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн асуудлыг шийдвэрлэж дуусгах ;
- Урт нэртэй хуульд хамрагдсан тусгай зөвшөөрлүүдийн асуудлыг шийдвэрлэх;
- Бүс нутгийн хувьд стратегийн болон ач холбогдол бүхий ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахад баримтлах дэд бүтцийн асуудлыг бүс нутгийн хөгжлийн онцлогт тохируулан боловсруулах;
- Уулын ажлын тайлан, төлөвлөгөөг онлайн хэлбэрээр авдаг болсныг хэвшүүлэх, сайжруулах;
- Орхигдсон газрын тооллого хийх, нөхөн сэргээлтэд тавих хяналтыг сайжруулах;
- Бичил уурхайн зохицуулалтыг улам боловсронгуй болгох.

Цаашид хийж гүйцэтгэх ажил, баримтлах бодлого

- Нүүрс боловсруулах үйлдвэрүүдийг бодлогоор дэмжиж ажиллах;
- Төрийн өмчит нүүрсний уурхайнуудын урт удаан хугацааны өр авлага, зээл, хөрөнгө оруулалтын асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлэх;
- “Нүүрс” хөтөлбөрийг УИХ-аар батлуулах, хэрэгжүүлж эхлэх;
- Монгол улсын нүүрсний батлагдсан нөөцийг нэмэгдүүлэх;
- Түүхий нүүрсний экспортын татварыг бий болгох, өртөг шингэсэн, боловсруулсан эцсийн бүтээгдэхүүнд татварын хөнгөлөлт үзүүлэх;
- Нүүрсний бирж байгуулах асуудлыг шийдвэрлүүлэх;
- Багануур, Шивээ-Овоо, Адуунчулууны уурхайн ордын нөөцийн асуудлыг шийдвэрлэх талаар санал боловсруулах.

Цаашид хийж гүйцэтгэх ажил, баримтлах бодлого

- Кадастрыг бүрэн автоматжуулах, өргөдөл шийдвэрлэлтийн байдлыг цахим хэлбэрээр олон нийтэд ил тод, нээлттэй, шуурхай хүргэх тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх;
- Кадастрын бүртгэлийн зарим техникийн шаардлагуудыг хуулинд тодорхой тусгуулах, тодорхой болгох;
- ГУУ-н кадастрыг олон улсын жишгийн дагуу нэгж талбараар бүртгэдэг системд шилжүүлэх талаар санал боловсруулах;
- Монгол улсад бүртгэгдэж байгаа газрын бүртгэл мэдээллийн баазуудыг нэг стандартад оруулах, уялдуулах асуудлыг судлах.

Цаашид хийж гүйцэтгэх ажил, баримтлах бодлого

- Ажиллагсадын орон сууц, нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх;
- Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн батлуулах, дагалдах дүрэм журмуудыг шинэчлэх;
- Шинээр батлагдсан болон хэрэгжиж буй хуулийг боловсронгуй болгоход чиглэсэн заавар, журмыг боловсруулж, мөрдүүлэх;
- Байгууллагын хэвийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр, чадавхийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;
- Ажилтан албан хаагчдын ажлын ачааллыг нягтруулах, ажлын үр ашгийг нэмэгдүүлэх талаар тодорхой төлөвлөгөөт ажлуудыг хийж гүйцэтгэх;
- Байгууллагын хүний нөөцийн чадавхийг сайжруулах, сургалт, давтан сургалтад зарцуулагдах хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх талаар тодорхой санал боловсруулах, хэрэгжүүлэх.



АНХААРЛ ТАВЬСАНД
БАЯРЛАЛАА!